



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/184/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-14
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

БАРУУНБҮРЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ П.ЭНХТУЯА ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/184/НА-СТА-ТШЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус сургууль нь 23,058.6 мянган төгрөгийн бүртгэлд тусгагдаагүй байсан газрыг орлогод авч, аймгийн хөрөнгө оруулалтаар 138,915.4 мянган төгрөгийн сургуулийн гадна пасад, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 68,000.0 мянган төгрөгийн ширээ сандал, Дезерет олон улсын байгууллагаас 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Боловсролын газраас 62,100.1 мянган төгрөгийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, зөөврийн компьютер, ухаалаг телевизор, сургуулийн 100 жилийн ойн хүрээнд төгсөгчдийн хандиваар 155,309.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, ширээ, сандал, зөөврийн компьютер зэргийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9

удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	324,861,569.47	522,843,324.27
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	220,885,729.27	311,299,833.19
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	220,885,729.27	311,299,833.19
3121	Төгрөг	220,885,729.27	311,299,833.19
31211	Төрийн сангийн харилцах	220,885,729.27	311,299,833.19
35	БАРАА МАТЕРИАЛ	103,975,840.20	211,543,491.08
351	Түүхий эд материал	626,800.00	300,800.00
3513	Эм боох материал	626,800.00	300,800.00
354	Хангамжийн материал	103,349,040.20	211,242,691.08
3541	Бичиг хэргийн материал	25,711,050.66	44,364,202.71
3542	Аж ахуйн материал	77,637,989.54	166,878,488.37
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,786,890,605.81	2,180,094,997.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,786,890,605.81	2,180,094,997.84
392	Биет хөрөнгө	1,765,787,839.29	2,136,037,797.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,709,040,297.00	1,904,329,772.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(132,685,642.71)	(205,163,422.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,500.00)	(14,562,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	215,098,783.51	323,110,221.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	(108,078,260.25)	(95,235,674.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	107,090,398.28	227,415,217.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(64,550,283.55)	(60,015,242.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,767,889.00	26,767,889.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,351,732.60)	(7,622,079.12)
39217	Ном	19,456,390.61	22,451,116.80
393	Биет бус хөрөнгө	21,102,766.52	44,057,200.00
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,145,833.48)	(1,250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,998,600.00	44,057,200.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,111,752,175.28	2,702,938,322.11
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		26,509,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		26,509,500.00
413	Өглөг		26,509,500.00
4136	Бусад өглөг		26,509,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг		26,509,500.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,111,752,175.28	2,676,428,822.11
51	Засгийн газрын хувь оролцоо	2,111,752,175.28	2,676,428,822.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	605,059,296.25	628,117,896.25
51101	Өмч: - төрийн		23,058,600.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,182,013,647.31	1,723,631,694.14
5121	Өмнөх үеийн үр дүн	1,182,013,647.31	1,182,013,647.31
5122	Тайлант үеийн үр дүн		541,618,046.83
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	324,679,231.72	324,679,231.72
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,111,752,175.28	2,702,938,322.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,277,072,385.16	2,547,020,945.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	842,594,631.16	501,792,209.40
120	Нийтлэг татварын бус орлого	842,594,631.16	501,792,209.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	842,594,631.16	501,792,209.40
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	842,594,631.16	501,792,209.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,434,477,754.00	2,045,228,735.66
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,226,527,500.00	1,807,414,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,226,527,500.00	1,807,414,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,581,254.00	4,798,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,547,948.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,033,306.00	4,798,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	202,369,000.00	233,015,235.66
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	202,369,000.00	233,015,235.66
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,396,122,453.37	2,003,972,449.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,396,122,453.37	2,003,972,449.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,325,892,303.37	1,941,464,899.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	851,959,169.88	1,300,364,769.29
210101	Үндсэн цалин	611,781,350.01	832,353,347.32
210102	Нэмэгдэл	199,317,837.87	411,677,774.92
210104	Урамшуулал	40,859,982.00	56,333,647.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,655,699.36	163,452,408.24
210201	Тэтгэврийн даатгал	74,034,529.24	112,060,589.28
210202	Тэтгэмжийн даатгал	8,709,944.67	13,187,035.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,827,155.75	6,654,750.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,644,006.42	6,310,006.86
210205	Эрүүл мэндийн даатгал	16,440,063.28	25,240,026.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,369,000.00	174,990,035.66
210301	Гэрэл, цахилгаан	15,268,035.56	17,988,761.67
210302	Түлш, халаалт	138,060,264.44	144,201,273.99
210303	Цэвэр, бохир ус	9,040,700.00	12,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,509,560.00	23,348,229.00
210408	Бараа материал акталсны зардал	2,509,560.00	23,348,229.00
2105	Нормативт зардал	86,224,900.00	89,422,150.00
210502	Хоол, хүнс	86,224,900.00	89,422,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,444,800.00
210604	Урсгал засвар		8,444,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,564,346.56	18,162,918.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,928,300.00	4,608,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,636,046.56	13,554,018.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,609,627.57	163,279,588.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,020,474.31	38,416,689.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,611,650.00	10,985,508.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,977,503.26	113,877,391.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,230,150.00	62,507,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,230,150.00	62,507,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,237,650.00	62,507,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,992,500.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	880,949,931.79	543,048,495.44
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,100,021.90	1,430,448.61
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,100,021.90	1,430,448.61
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,100,021.90)	(1,430,448.61)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	873,849,909.89	541,618,046.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,434,477,754.00	2,045,228,735.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,434,477,754.00	2,045,228,735.66
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,226,527,500.00	1,807,414,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,226,527,500.00	1,807,414,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,581,254.00	4,798,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,547,948.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,033,306.00	4,798,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	202,369,000.00	233,015,235.66
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	202,369,000.00	233,015,235.66
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,341,622,871.11	1,905,944,631.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,341,622,871.11	1,905,944,631.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,271,392,721.11	1,843,437,081.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	851,959,169.88	1,300,329,769.29
210101	Үндсэн цалин	611,781,350.01	832,318,347.32
210102	Нэмэгдэл	199,317,837.87	411,677,774.92
210104	Урамшуулал	40,859,982.00	56,333,647.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,655,699.36	163,452,408.24
210201	Тэтгэврийн даатгал	74,034,529.24	112,060,589.28
210202	Тэтгэмжийн даатгал	8,709,944.67	13,187,035.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,827,155.75	6,654,750.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,644,006.42	6,310,006.86
210205	Эрүүл мэндийн даатгал	16,440,063.28	25,240,026.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,369,000.00	174,990,035.66
210301	Гэрэл, цахилгаан	15,268,035.56	17,988,761.67
210302	Түлш, халаалт	138,060,264.44	144,201,273.99
210303	Цэвэр, бохир ус	9,040,700.00	12,800,000.00
2105	Нормативт зардал	86,224,900.00	89,422,150.00
210502	Хоол, хүнс	86,224,900.00	89,422,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,940,713.00	9,395,200.00
210604	Урсгал засвар	5,940,713.00	9,395,200.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,564,346.56	18,162,918.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,928,300.00	4,608,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,636,046.56	13,554,018.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,678,892.31	87,684,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,844,644.31	71,690,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,834,248.00	15,994,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,230,150.00	62,507,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,230,150.00	62,507,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,237,650.00	62,507,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,992,500.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	92,854,882.89	139,284,103.92
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	77,891,387.00	48,870,000.00
	Дотоод эх үүсвэрээр	77,891,387.00	48,870,000.00
221001	Их засвар	34,059,287.00	48,630,000.00
222001	Тоног төхөөрөмж	41,411,100.00	
223001	Бусад хөрөнгө	2,421,000.00	240,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(77,891,387.00)	(48,870,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	14,963,495.89	90,414,103.92
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		220,885,729.27
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		311,299,833.19

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	605,059,296.25	324,679,231.72	1,182,013,647.31	2,111,752,175.28
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	23,058,600.00			23,058,600.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			547,740,754.83	547,740,754.83
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	605,059,296.25	324,679,231.72	1,182,013,647.31	2,111,752,175.28
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	23,058,600.00			23,058,600.00
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			541,618,046.83	541,618,046.83
16	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	628,117,896.25	324,679,231.72	1,723,631,694.14	2,676,428,822.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,267,255,200.00	1,954,814,631.74	312,440,568.26	86.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,267,255,200.00	1,954,814,631.74	312,440,568.26	86.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,193,891,100.00	1,892,307,081.74	301,584,018.26	86.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,522,400,600.00	1,300,329,769.29	222,070,830.71	85.4
210101	Үндсэн цалин	990,652,300.00	832,318,347.32	158,333,952.68	84.0
210102	Нэмэгдэл	500,923,000.00	411,677,774.92	89,245,225.08	82.2
210104	Урамшуулал	30,825,300.00	56,333,647.05	(25,508,347.05)	182.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	190,300,200.00	163,452,408.24	26,847,791.76	85.9
210201	Тэтгэврийн даатгал	129,404,000.00	112,060,589.28	17,343,410.72	86.6
210202	Тэтгэмжийн даатгал	15,224,000.00	13,187,035.08	2,036,964.92	86.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,612,100.00	6,654,750.80	957,349.20	87.4
210204	Ажилгүйдлийн даатгал	7,612,100.00	6,310,006.86	1,302,093.14	82.9
210205	Эрүүл мэндийн даатгал	30,448,000.00	25,240,026.22	5,207,973.78	82.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,817,600.00	174,990,035.66	1,827,564.34	99.0
210301	Гэрэл, цахилгаан	10,952,100.00	17,988,761.67	(7,036,661.67)	164.3
210302	Түлш, халаалт	155,016,700.00	144,201,273.99	10,815,426.01	93.0
210303	Цэвэр, бохир ус	10,848,800.00	12,800,000.00	(1,951,200.00)	118.0
2105	Нормативт зардал	111,843,400.00	89,422,150.00	22,421,250.00	80.0
210502	Хоол, хүнс	111,843,400.00	89,422,150.00	22,421,250.00	80.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,025,200.00	58,025,200.00		100.0
210604	Урсгал засвар	58,025,200.00	58,025,200.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,621,300.00	18,162,918.55	21,458,381.45	51.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,608,900.00	4,608,900.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,012,400.00	13,554,018.55	21,458,381.45	38.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,882,800.00	87,924,600.00	6,958,200.00	92.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,888,500.00	71,930,300.00	6,958,200.00	91.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,994,300.00	15,994,300.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,364,100.00	62,507,550.00	10,856,550.00	85.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,364,100.00	62,507,550.00	10,856,550.00	85.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	73,364,100.00	62,507,550.00	10,856,550.00	85.2
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,267,255,200.00	2,045,228,735.66	222,026,464.34	90.4
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,027,613,500.00	1,812,213,500.00	215,400,000.00	89.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,027,613,500.00	1,807,414,600.00	220,198,900.00	89.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,798,900.00	4,798,900.00	-	100.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,798,900.00	4,798,900.00	-	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	234,842,800.00	233,015,235.66	1,827,564.34	99.2
132001	Орон нутгийн төсвөөс	234,842,800.00	233,015,235.66	1,827,564.34	99.2
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		220,885,729.27	(220,885,729.27)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		311,299,833.19	(311,299,833.19)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь “Багш суралцагчдын тасралтгүй хөгжлийг дэмжиж хамтран ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг чанаржуулж, багш бүрийн мэдээлэл технологийн чадварыг сайжруулан цахим контентын сан бүрдүүлэх оролцоог нэмэгдүүлж, бүтээлчээр ашиглах,
- Суралцагчдын сурлагын хоцрогдлыг арилгахад багш, сурагч, эцэг эхийн олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээг баримтлан, харилцааны эерэг хандлагатай байгууллагын соёлыг бүрдүүлэх,
- Суралцагчдын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг дэмжин, сурч хөгжих эрүүл аюулгүй, тэгш, хүртээмжтэй орчин нөхцөлөөр хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 591,186.1 мянган төгрөгөөр буюу 28.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	220,885.7	311,299.8	90,414.1
Авлага	-	-	-
Бараа материал	103,975.9	211,543.5	107,567.6
Үндсэн хөрөнгө	1,786,890.6	2,180,095.0	393,204.4

Нийт хөрөнгө	2,111,752.2	2,702,938.3	591,186.1
Өр төлбөр	-	26,509.5	26,509.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,111,752.2	2,676,428.8	564,676.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,111,752.2	2,702,938.3	591,186.1

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 311,299.8 мянган төгрөг болж 90,414.1 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 211,543.5 мянган төгрөг болж 107,567.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 257,747.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 11,945.6 мянган төгрөгийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, төгсөгчдийн хандиваар 53,262.9 мянган төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, захирлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар 23,348.2 мянган төгрөгийн цаашид ашиглах боломжгүй хангамжийн бараа материалыг акталж, үйл ажиллагаанд 192,039.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,180,095.0 мянган төгрөг болж 393,204.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 240.0 мянган төгрөгийн ном, 48,630.0 мянган төгрөгийн гал тогоо, угтах хэсгийн дотор заслын ажил хийгдэж, тайлант онд 23,058.6 мянган төгрөгийн бүртгэлд тусгагдаагүй байсан газрыг орлогод авч, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 138,915.4 мянган төгрөгийн сургуулийн гадна пасад, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 68,000.0 мянган төгрөгийн ширээ сандал, аймгийн Боловсролын газраас 50,154.5 мянган төгрөгийн сурах бичиг, зөөврийн компьютер, ухаалаг телевизор, Боловсролын газраас 60,065.7 мянган төгрөгийн ширээ сандал, химийн кабинетын тоног төхөөрөмж, суурин компьютер, ухаалаг дэлгэц, Дезерет олон улсын байгууллагаас 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, төгсөгчдийн хандиваар 102,046.2 мянган төгрөгийн ширээ, сандал, зөөврийн компьютер зэрэг хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор цаашид ашиглах боломжгүй 58,833.1 мянган төгрөгийн хөрөнгө акталж, тайлант онд 113,877.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 26,509.5 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын яамны ерөнхий гэрээний дагуу төсвийн хөрөнгөөр Персон хөтөлбөрийн хүрээнд 2 жилийн хугацаатай лизингийн гэрээгээр утасгүй интернэтийн төхөөрөмжийг Юнивишн ХХК-аас хүлээн авч өр төлбөр үүсгэснээс тус тус шалтгаалсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,697,853.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 131,436.5 мянган төгрөг нийт 1,829,289.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 334,559.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,032,412.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 103,406.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 234,842.8 мянган төгрөгөөр, нийт 2,267,255.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,806,727.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 234,842.8 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,798.9 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 220,885.7 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **2,267,255.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 277,895.3 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардлыг 45,381.1 мянган төгрөгөөр,
- Урсгал засварын зардлыг 58,025.2 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 9,536.4 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 6,809.1 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 39,621.3 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 696.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,032,412.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 234,842.8 мянган төгрөг, нийт 2,267,255.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,954,814.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,954,814.6 мянган төгрөг буюу 86.2 хувьтай байгаа нь үдийн цай хөтөлбөрийн зардлыг 10,856.7 мянган төгрөгөөр, дотуур байрны зардлыг 60,373.8 мянган төгрөгөөр, бичиг үсгийн боловсролын хөтөлбөрийн зардлыг 27,416.4 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 203,766.9 мянган төгрөгөөр, бусад зардлыг 8,886.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	2,032,412.40	1,721,799.40	311,299.8	84.7
80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	3,892.80	3,892.80	-	100.0
80233-Хүүхэд хамгаалал	3,830.60	1,755.20	2,075.40	45.8
80312 - Сургалт семинар	2,595.20	2,595.20	-	100.0
81605 - Эрүүл мэндийг дэмжих	3,892.80	3,892.80	-	100.0
81801 - Үдийн цай хөтөлбөр	73,364.20	62,507.50	10,856.70	85.2

81806 - Дотуур байр	314,252.20	253,878.40	60,373.80	80.8
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	26,509.50	26,509.50	-	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	11,995.70	8,301.40	3,694.30	69.2
81827 - Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	27,839.80	423.40	27,416.40	1.5
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,522,735.70	1,319,655.60	203,766.90	86.7
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	30,615.00	30,614.90	0.10	100.0
81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	190.00	190.00	-	100.0
81848-Сурах бичгийн түрээс	4,608.90	4,608.90	-	100.0
81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	6,090.00	2,973.80	3,116.20	48.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих	234,842.80	233,015.20	1,827.60	100.0
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	234,842.80	233,015.20	1,827.60	99.2
ДҮН	2,267,255.20	1,954,814.60	313,127.40	86.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Үдийн цайны материал	66,555.0	66,555.0	ХТШ
2	Дотуур байрны хоол	99,000.0	99,000.0	ХТШ
	Нийт дүн	165,555.0	165,555.0	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад "Бүрэн хаан өгөөж" ХХК, "Бүрэн шувуут" ХХК оролцож, гүйцэтгэгчээр "Бүрэн хаан өгөөж" ХХК шалгаран 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах, нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой, анхан шатны баримтыг бүрдүүлэн ажил гүйлгээг хийж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,396,122.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 20,941.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/45 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,735.1 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт
----------	------------------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	715.9	1	715.9	100.0
Албан шаардлага	2	5,019.2	2	5,019.2	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	4	5,735.1	4	5,735.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 40,738.1 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Боловсролын ерөнхий газраас 2 жилийн хугацаагаар лизингээр нийлүүлэгдэж буй утасгүй интернэтийн сүлжээний тоног төхөөрөмжийн үлдэгдэл 26,509.5 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд өр төлбөрөөр тусгаагүй, хөрөнгийг үнэн зөв ангилж бүртгээгүй,
- Үр дүнгийн тайланд хичээл практикийн зардлын 9,908.7 мянган төгрөгийг дутуу тайлагнаснаас үр дүнг буруу илэрхийлсэн,
- Эргэлтийн хөрөнгөөр бүртгэгдэх 4,319.9 мянган төгрөгийн Персон хөтөлбөрийн сурах бичгийг үнэн зөв ангилалгүй үндсэн хөрөнгөд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 19,932.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч 3,937.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1. Албан шаардлага

1. Зайлшгүй шаардлагаар буюу мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас сургалтын менежерүүдэд долоо хоногт заах тогтоосон хэмжээг хэтрүүлэн хичээл заасан гэх үндэслэлээр 3,937.7 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, БШУЯ-ны сайдын 2023 оны А/386 тоот тушаал 1.1 “*Мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас хичээл, сургалтын тасралтгүй байдал алдагдахад хүрсэн тохиолдолд тухайн сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер болон бусад багш мэргэжилтэй ажилтнаар мэргэжлийн дагуу долоо хоногт 6 хүртэл цагийн хичээл заах нөхцөлийг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Няrvын тайланд 15,994.3 мянган төгрөгийн хичээл практикийн сургалтын хэрэглэгдэхүүнийг багш нарт шаардах хуудсаар олгон зарцуулсан боловч үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг гарсан тухай бүр анхан шатны баримтыг үндэслэн бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд өр төлбөр тусгаагүй	1	26,509.5	1	26,509.5			1	26,509.5				
Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн	1	4,319.9			1	4,319.9	1	4,319.9				
Зардал дутуу тайлагнасан	1	9,908.7	1	9,908.7			1	9,908.7				
Дүн	3	40,738.1	2	36,418.2	1	4,319.9	3	40,738.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сургалтын менежерийн хичээл заах цагийг хэтрүүлэн нэмэгдэл цалин олгосон	1	3,937.7			1	3,937.7						
Зарцуулсан бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан	1	15,994.3					1	15,994.3				
Дүн	2	19,932.0			1	3,937.7	1	15,994.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								